



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.02.18 № 06

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г ОРХОН АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР,  
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА  
Д.ДЭЛГЭРБАЯР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Орхон аймгийн Биеийн тамир, спортын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Орхон аймгийн Биеийн тамир, спортын газар нь орон нутгийн төсвөөс Улсын төсвийн төрийн захиргааны байгууллагын албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл 74,977.96 мянган төгрөг, Эрдэнэт, спорт амралтын хүрээлэнгийн гэрээт харуул 6 албан хаагчийн цалин 133,470.6 мянган төгрөг, чөлөөт бөхийн U17 насны аварга шалгаруулах тэмцээний зардал 50,000.0 мянган төгрөг, жудо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээний зардал 15,000.0 мянган төгрөг, таеквондогийн улсын аварга шалгаруулах тэмцээний зардал 22,500.0 мянган төгрөг, бусад аймаг, бүс нутгийн тэмцээн уралдаан зохион байгуулах зардал нийт 624,510.8 мянган төгрөгийн санхүүжилтийг хүлээн авсан байна.

**Аудитын гол асуудал**

Орхон аймгийн Биеийн тамир, спортын газар нь орон нутгийн 2024 оны хөрөнгө оруулалтаар аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнгийн засварыг 86,000.0 мянган төгрөг, цэнгэлдэх хүрээлэнгийн цахилгааны кабелийн засварыг 9,000.0 мянган төгрөг, цэнгэлдэх хүрээлэнгийн чийрэгжүүлэлтийн талбай 151,956.66 мянган



төгрөг, суулт шахалтын төхөөрөмж дагалдах хэрэгслийн хамт 115,920.0 мянган төгрөг нийт 362,876.66 мянган төгрөгөөр гүйцэтгэн хүлээлгэж өгснийг хөрөнгөд бүртгэсэн нь үндсэн хөрөнгө өсөхөд нөлөөлсөн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилт, 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай байгуулж, хэрэгжилтийг 99.3 хувьтай үнэлэгдсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА